

ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН 2026 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН БИЕЛЭЛТ

2026.06.10

Д/Д	Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж	Төсөв	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин	Хэрэгжилт	Хувь
Нэг. Бодлогын баримт бичигт тусгагдсан зорилт, арга хэмжээ							
1.1	“Алсын хараа 2050” бодлогын баримт тусгагдсан зорилт, арга хэмжээ						
1.1.1	Хүүхдийн сэргийлж болох эндэгдэлд нөлөөлөх хүчин зүйлийг багасгаж, нялхасын болон 1-5 хүртэлх насны хүүхдийн эндэгдлийг бууруулах.	Улсын төсөв	1-5 хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн түвшин Нялхсын эндэгдлийн түвшин	1-5 хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн түвшин-0.7 Нялхсын эндэгдлийн түвшин-15.2	1-5 хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн түвшин-0.6 Нялхсын эндэгдлийн түвшин-15.0	Аймгийн хэмжээнд 2026 оны 5 сарын байдлаар нялхсын эндэгдлийн эндэгдлийн түвшин 12.2 байгаа нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 2.7 промилээр буурсан, 5 хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн түвшин 12.2 байгаа нь улс, аймгийн дунджаас 2.2-3.0 буурсан үзүүлэлттэй байна. 2025 оны тав хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн байдалд дүн шинжилгээ хийж сэргийлж болох эндэгдэл нөлөөлөх хүчин зүйлийг судалж дараах ажлуудын зохион байгуулсан. Үүнд: 5 сэдвээр сургалт зохион байгуулан Эрүүл мэндийн байгууллагуудын 156 эмч эмнэлгийн мэргэжилтнүүдийг цахим болон танхимаар хамруулсан. (ХӨЦМ-өөс Хүүхдийн эрчимт эмчилгээ-2026” сэдэвт бүсчилсэн сургалт, Хүүхдийн өвчний цогц менежмент, Хүүхдэд тохиолдох томуу, томуу төст өвчнөөс урьдчилан сэргийлэх арга, эмнэл зүйн заавар, Бага насны хүүхдийг осол гэмтлээс сэргийлье, Хүүхдийн НУУР (нүдний угийн улаан рефлекс)-ийн үзлэг зохион байгуулах) - Эх, хүүхэд, нөхөн үржихүйн тусламж үйлчилгээг сайжруулах чиглэлээр 2 удаагийн зөвлөмж хүргүүлсэн.	100

						“Жирэмсэн эмэгтэйн хяналтын хөтөч карт хөтлөлтийг үнэлэх шалгуур хуудас”, “Төрсний дараах тусламж, үйлчилгээ үзүүлсэн байдлыг үнэлэх, шалгуур хуудас”, манас таталтын иж бүрдэл болон тусламж үйлчилгээний мэдлэгийг үнэлэх шалгуур хуудас” боловсруулан ЭМГ-ын даргын 2026 оны А/36 дугаар (Шалгуур хуудас шинэчлэн батлах тухай) тушаалаар баталгаажуулан ЭМБ-уудад хүргүүлэн, Рашаант, Гурванбулаг сум, “Цоожэд”, “Эмийн цэцэглэн” өрхийн ЭМТ-д үнэлгээ хийсэн. "Эмнэлгийн болон эмнэлгийн бус нөхцөлд эндсэн тав хүртэлх насны хүүхдийн эндэгдлийг хэлэлцэх аймгийн зөвлөлийн бүрэлдэхүүн", “Эхийн ноцтой хүндрэл, эхийн болон перинатал эндэгдлийг хэлэлцэх аймгийн зөвлөлийн бүрэлдэхүүн” “Зөвлөлийн ажиллах журам”, “Эмнэлгийн бус нөхцөлд эндсэн эхийн болон тав хүртэлх насны хүүхдийн эндэгдлийг эмгэг судлалын шинжилгээнд оруулах журам”, “Эх, хүүхдийн өвчлөл эндэгдлийн мэдээллийн урсгал”-ыг боловсруулан ЭМГ-ын А/37 дугаар “Журам шинэчлэн батлах тухай” тушаалаар баталгаажуулсан.	
1.2	МУ-ын Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан зорилт, арга хэмжээ						
1.2.1	Хорт хавдартай тэмцэх, сэргийлэх арга хэмжээний төлөвлөгөөг хэрэгжүүлэх.	УТ	Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь	90	95	ЭМС-ын 2025 оны А/241 дугаар тушаалаар батлагдсан “Хорт хавдартай тэмцэх, сэргийлэх арга хэмжээний төлөвлөгөөг” 2026 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны	100

						төлөвлөгөө боловсруулан батлуулан хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Хавдар судлалын үндэсний төвтэй хамтарсан “Умайн хүзүүний хорт хавдрын эрт илрүүлэгт хүний папилома вирус тодорхойлох нь” сургалтад 20 эх баригчыг хамруулсан. Эх баригч нарт хүний папилома вирус тодорхойлох шинжилгээ авах арга аргачлал, умайн хүзүүний хорт хавдрыг эрт илрүүлэг үзлэгийг ncc.gerege.mn праграммд шивж оруулах. Аймгийн хэмжээнд 2026 оны 4-р сарын байдлаар хавдар өвчний 59 тохиолдлыг шинээр илрүүлж, хяналтанд 753 иргэн байна. Хавдрын хөнгөвчлөх тусламж үйлчилгээг үзүүлж, 11 байрлалын хавдартай 47 иргэнийг хэвтүүлэн эмчилсэн. АНЭ-ийн амбулатороор хавдрын тусламж үйлчилгээ авч буй иргэд тэдний гэр бүлийнхэн эрсдэлт хүчин зүйлсийн талаар 2330 иргэд зөвлөгөө өгч ажилласан. ЭМБ-уудын 154 эмч, эмнэлгийн мэргэжилтэн нарт танхим болон цахимаар Хорт хавдар өвчний өнөөгийн байдал, тусламж үйлчилгээний талаар сургал хийсэн. Хавдрын эрт илрүүлэгт хагс жилийн байдлаар 421 хамрагдсан байна.	
1.2.2	Иргэдэд тэнцвэртэй хооллолт, хоол хүнсний зөв хэрэглээг таниулах мэдээлэл сургалт,	УТ	Сургалтын тоо-Сурталчилгаанд хамрагдсан иргэдийн тоо Цахим орчинд байршуулсан мэдээллийн тоо	• Сургалтын тоо-14 • Сурталчилгаанд хамрагдсан	• Сургалтын тоо-16 • Сурталчилгаанд хамрагдсан иргэдийн тоо-2000	"Эрүүл хооллолт-эрүүл амьдралын үндэс" сарын аяны хүрээнд 8 удаагийн сургалтаар 570 гаруй иргэнд "Тэнцвэртэй хооллолт", Эмчилгээний хоолны чиглэлээр мэдээлэл сургалт, сурталчилгааг зохион байгуулан ажиллаа. Нийт давхардсан тоогоор	100

	сурталчилгааны нөлөөллийн ажлыг зохион байгуулах.			иргэдийн тоо-2700 • Цахим орчинд байршуулах мэдээллийн тоо 52	• Цахим орчинд байршуулах мэдээллийн тоо 32	1000 гаруй иргэнийг хамруулсан сургалт, сурталчилгаа зохион байгуулж, эрүүл амьдралын хэв маягийг төлөвшүүлэхэд чиглэсэн үйл ажиллагааг зохион байгуулсан. Могод сумын ЗДТГ, ЭМТ, аймгийн тогооч нарын холбоотой хамтран Могод сумын төрийн болон хувийн хэвшлийн байгууллагуудын хоол үйлдвэрлэлийн 10 тогооч нарын дунд ур чадварын тэмцээн, сургалтыг зохион байгууллаа чиглэлээр мэдээлэл сургалт, сурталчилгааг зохион байгуулана ажиллаа.	
1.2.3	Нас, хүйс, эрүүл мэндийн эрсдэлд суурилсан урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэг үзлэгийг зорилтот бүлгийн хамруулан зохион байгуулах.	ОНТ-30.0	Эрт илрүүлгийн хамрагдалтын хувь	50.5	50.8	Халдварт бус өвчний эрт илрүүлэг үзлэгт зорилтод насны иргэдийн 20,939 буюу 24.7% нь хамрагдсан байна. Аймгийн НЭ-ийн дэмжих төвөөр 782 иргэнийг нарийн мэргэжлийн эмчийн урьдчилан сэргийлэх үзлэг оношилгоонд хамруулсан. Хавдрын эрт илрүүлэгт хэвийн тодосгогчтой-38, тодосгогчгүй-10 компьютерийн томографийн шинжилгээ хийж, элэгний хавдартай 2 иргэнийг илрүүлсэн. Амьсгалын замын хүнд зовиуртай болон удаан хугацаагаар тамхи тасан иргэдэд уушгины хорт хавдрын эрт илрүүлэх цээжний тодосгогчтой-11 болон тодосгогчгүй-24 иргэнд компьютерийн томографийн шинжилгээ, Ходоод, улаан хоолойн хорт хавдрын илрүүлэх дурангийн шинжилгээнд 338 иргэн хамрагдсанаас 61 иргэн давтан дуран дуулах, 1 иргэн ходоодны хавдраар оношлогдсон. Хавдрын эрт илрүүлэгт нийт 421 хамрагдаж хагас жилийн байдлаар аймгийн хэмжээнд эрт илрүүлэг үзлэгийн хамрагдалт 51%-д хүрч, өмнөх оноос 0.3%-иар өссөн байна. "Эрүүл шүд" хөтөлбөрийн хүрээнд 18	100%

						хүртэлх насны хүүхдийн шүд, амны хөндийн эрүүл мэндийг сайжруулах, үзлэг, эмчилгээ, зөвлөгөө өгөхөөр Баяннуур, Бүрэгхангай сумын эрүүл мэндийн төв "Ц.Бадрал" сан, АШУИС-ийн Нүүр ам судлалын сургуультай хамтран үзлэг зохион байгуулан 823 хүүхдэд амны хөндийн урьдчилан сэргийлэх үзлэг, 268 хүүхдэд эмчилгээ, цооролтой 881 шүдэнд тусламж үйлчилгээ үзүүлсэн байна.	
1.3	Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан зорилт, арга хэмжээ.						
1.3.1	Аймгийн Засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны "Булганы сэргэлт" Хөтөлбөрийг хэрэгжүүлэх байгууллагын төлөвлөгөөг баталж, ТЗУХ-д хүргүүлэн хэрэгжилтийг зохион байгуулах.		Ирүүлсэн төлөвлөгөөний тоо	-	1	Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны "Булганы сэргэлт" хөтөлбөрийг хэрэгжүүлэх байгууллагын төлөвлөгөөг боловсруулан аймгийн Засаг даргаар баталгаажуулан ТЗУХ-д хүргүүлсэн.	100
			Хэрэгжилтийн хувь		85-с доошгүй хувь	Байгууллагын 2026 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилт эхний хагас жилийн байдлаар 98.3 хувьтай хэрэгжсэн.	100
1.3.2	Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах хүрээнд батлагдсан 13 дэд хөтөлбөрөөс өөрийн байгууллагад хамаарах хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөөг 1 дүгээр улиралд багтаан ТЗУХ-д хүргүүлэх, хэрэгжилтийг зохион байгуулах.	-	Ирүүлсэн төлөвлөгөөний тоо		1	Эрүүл Булган хөтөлбөрийг 2026 онд хэрэгжүүлэх 4 зорилт 28 арга хэмжээ бүхий үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулан батлуулсан.	100
			Хэрэгжилтийн хувь		85-с доошгүй хувь	2026 оны эхний хагас жилийн хэрэгжилт 70%	70
1.3.3	Нас, сэтгэхүйн онцлогт тохирсон контент, мэдээллийг бэлтгэн эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх сургалт,	10,0	Телевизийн ярилцлага, нэвтрүүлэг, контент, сурталчилгааны тоо	Телевизийн ярилцлага-4, нэвтрүүлэг-6, контент-5, сурталчилгаа-	Телевизийн ярилцлага-6, нэвтрүүлэг- 8, контент-7 сурталчилгаа-18 удаа	"Хүн амд эрүүл мэндийн боловсрол олгох сургалт сурталчилгааг төрийн болон ТББ, иргэдийн дунд зохион байгуулан ажиллаж байна. Эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх чиглэлээр 16 удаагийн тахимийн	100

	сурталчилгааг цахимаар түгээн дэлгэрүүлэх.			14 удаа		сургалтнд 736 иргэдийг хамруулж, сурталчилгаанд давхардсан тоогоор 7483 иргэнийг хамруусан. иргэд олон нийтэд эрүүл мэндийн мэдээлэл түгээх чиглэлээр Эрүүл мэндийн яам, НЭМҮТ, аймгийн эрүүл мэндийн газарын бэлтгэсэн 6 төрлийн контентыг ашиглан 6 удаагийн нэвтрүүлэг, 18 ширхэг рийл, 1 видео шторк бэлтгэж, нийт 14 сэдвийн хүрээнд 53 удаагийн нэвтрүүлэг, контентыг олон нийтэд хүргэн ажилласан бөгөөд эдгээрийг байгууллагын албан ёсны цахим хуудас болох www.bu.mohs.gov.mn -д байршуулж, салбарын хэмжээнд зохион байгуулсан үйл ажиллагаа, сургалт, сурталчилгаа, зөвлөмж, видео шторк зэрэг 53 удаагийн мэдээ, мэдээллийг ил тод, нээлттэй байдлаар түгээсэн.	
1.3.4	Хорт зуршил, буруу хооллолт, хөдөлгөөний хомсдол зэрэг анхдагч эрсдэлт хүчин зүйлийг бууруулах мэдээлэл, сургалт, сурталчилгааны хамрах хүрээг нэмэгдүүлэх	10,0	Хамрагдсан хүн амын тоо	15,000	18,000	Хүн амын өвчлөл, нас баралтад нөлөөлдөг анхдагч эрсдэлт хүчин зүйлсийг бууруулах зорилгоор “Архи, тамхи – Шинэ үеийн сонголт биш” сарын аяныг жил бүрийн 3-р сард зохион байгуулдаг. Аяны хүрээнд 4 төрлийн сэдвээр 12 удаагийн сургалтаар 300 гаруй сурагчид, эрүүл мэндийн байгууллагаар үйлчлүүлж байгаа 128 иргэнд хорт зуршлын чиглэлээр нийт 428 иргэнд сургалт мэдээлэл өгч, 1500 гаруй сурталчилгааны материал тараасан. Хоргүй тамхи гэж байхгүй тамхинаас татгалзая уриан дор "Эрүүл залуу эх орны ирээдүй" контентыг бүтээж цахим орчинд сурталчилж 419 иргэн үзсэн “Дэлхийн тамхигүй өдөр”-ийн хүрээнд НЭМҮТ-өөс бэлтгэсэн постер, шторкыг өөрийн цахим хуудсан байршуулан олон нийтэд сурталчилж ажилласан. "Эрүүл хооллолт-эрүүл амьдралын үндэс" сарын аяны хүрээнд 570 гаруй иргэнд	100

						мэдлэгийг нэмэгдүүлэх зорилгоор “Тэнцвэртэй хооллолт”, Эмчилгээний хоолны чиглэлээр мэдээлэл сургалт, сурталчилгааг зохион байгуулан ажиллаа. Нийт 3000 гаруй иргэнийг хамруулсан сургалт, сурталчилгаа зохион байгуулж, хорт зуршлыг бууруулах, эрүүл амьдралын хэв маягийг төлөвшүүлэхэд чиглэсэн үйл ажиллагааг зохион байгуулсан ажиласан. Могод сумын ЗДТГ, ЭМТ, аймгийн тогооч нарын холбоотой хамтран Могод сумын төрийн болон хувийн хэвшлийн байгууллагуудын хоол үйлдвэрлэлийн 10 тогооч нарын дунд ур чадварын тэмцээн, сургалтыг зохион байгууллаа	
1.3.5	Иргэдэд ундны ус, сүү сүүн бүтээгдэхүүнийг хадгалах зориулалтын савны хэрэглээг нэмэгдүүлэх мэдээлэл, сургалт, сурталчилгааг зохион байгуулах.	20,0	Иргэдийн тоо	2500	2800	"Хөх савнаас хөхүүр лүү" эмч зөвлөж байна ведио контентийг боловсруулан Эрүүл мэндийн газрын болон бусад эрүүл мэндийн байгууллагуудын цахим хуудсаар иргэд олон нийтэд түгээсэн. Мөн аймгийн Засаг даргын санаачилгаар чөлөөлье аяны хүрээнд "Хөх савыг чөлөөлье" айргаа модон саванд хийж хэвшье зөвлөмжит мэдээллийг бэлтгэн Эрүүл мэндийн байгууллагуудын цахим хаягаар түгээсэн. Нийт үзэлтийн тоо 1300	70
1.3.6	Иргэдэд эмийн зохистой хэрэглээг төлөвшүүлэх, эмийн гаж нөлөө. Эрсдлээс сэргийлэх сургалт нөлөөлийн ажлыг зохион байгуулах	-	Сургалтын тоо	4	6	Эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах өдрийн тэмдэглэх ажлын хүрээнд НЭМХ, аймгийн “Эм холбоо”-той хамтран “Эрүүл мэнд Тэгш эрх” үйл ажиллагааг аймгийн хэмжээнд жилийн туршид хэрэгжүүлэх аяны удирдамж, төлөвлөгөөг боловсруулан Эрүүл мэндийн байгууллагуудад хүргүүлэн, хэрэгжилтэд хяналт тавин ажиллаж байна.	100

						Эмийн зохистой хэрэглээг төлөвшүүлэх зорилгоор "Эмийн зохистой хэрэглээ гэж юу вэ", "Антибиотикийн зохистой хэрэглээг иргэдэд төлөвшүүлэх нь" сэдвээр иргэдэд сургалт зохион байгуулж 8437 иргэн, цахим сүлжээгээр 11 төрлийн бичлэг, 26 төрлийн зөвлөгөө, мэдээллийг нийтэлж 10596 иргэн үзсэн байна. Мөн эрүүл мэндийн байгууллагууд сургалт нөлөөллийн ажлыг цахимаар болон танхимаар зохион байгуулан дотоодын сургалт давхардсан тоогоор 519, хэвтэн эмчлүүлж буй 1365, амбулатороор үйлчлүүлж буй 2946 иргэнд зөв хэрэглээг сурталчилсан байна. Аймгийн хэмжээнд зохион байгуулагдсан 2 удаагийн нээлттэй хаалганы өдрөөр "Эмийг жороор олгохын ач тус", "Эм хэрэглэх 5 зөвийн зарчим" зэрэг 5 төрлийн гарын авлагыг 300 иргэнд тарааж зөвлөгөө өгсөн.	
1.3.7	"Эрүүл ээжээс эрүүл хүүхэд" арга хэмжээг зохион байгуулан нөхөн үржихүйн насны эмэгтэйчүүдийг хөх, "CEK71CAN1 АГ" аппаратаар умайн хүзүүний хавдрын эрт илрүүлэг үзлэг, БЗДХ/ХДХВ, элэгний В, С вирус, хеликобактери зэрэг өвчин, эмгэгийг илрүүлэх үзлэг, оношилгоонд хамруулах		Хөхний өмөн, умайн хүзүүний өмөнгийн эрт илрүүлэгт хамрагдсан эмэгтэйчүүдийн тоо, хувь	Хөхний үзлэгт хамрагдсан эмэгтэйчүүдийн тоо 11116 Умайн хүзүүний өмөнгийн эрт илрүүлгийн 58.3 хувь	Хөхний үзлэгт хамрагдсан эмэгтэйчүүдийн тоо 12000 Умайн хүзүүний өмөнгийн эрт илрүүлгийн 60.0 хувь	Аймгийн хэмжээнд 2026 оны эхний 5 дугаар сарын байдлаар - Умайн хүзүүний өмөнгийн эрт илрүүлэг үзлэгт 1192 эмэгтэйчүүдийг хамруулж 29.5 хувь. - Хөхний өмөнгийн эрт илрүүлэг үзлэгт 5168 эмэгтэйчүүдийг хамруулж 33.6 хувьтай байна. Нөхөн үржихүйн насны эмэгтэйчүүдийг хиймэл оюун ухаан дээр суурилсан "CERVICARI AI" аппаратаар умайн хүзүүний хавдрын эрт илрүүлэг үзлэгт 125 эмэгтэйг хамруулсан. 81 эмэгтэй хэвийн, 44 эмэгтэйд эс, эдийн	70

						шинжилгээ өгөх шаардлагатай эмэгтэйчүүдийг илрүүлэн ажилласан. Мөн хүний папилома вирус илрүүлэх шинжилгээнд 60 эмэгтэйг хамруулснаас 24 эмэгтэйд хүний папилома вирус илэрсэн, эмчилгээнд хамруулан хяналтад авсан. Эхний 5 сард 289 жирэмсэн эмэгтэйг эмчийн хяналтад авч, товлोलт хугацаанд нь БЗДХ/ХДХВ, элэгний В, С вирус илрүүлэх түргэвчилсэн болон шээсэнд нян илрүүлэх шинжилгээнд тухай бүр нь хамруулсан. - БЗДХ өвчлөлтэй 4 жирэмсэн - Элэгний В вирусийн халдвартай 6 жирэмсэн - Элэгний С вирусийн халдвартай 2 жирэмсэн илрүүлэн нарийн мэргэжлийн эмчийн үзлэгт хамруулан эмчилгээ, хяналтыг тогтоож, шаардлагатай арга хэмжээг авч ажиллаж байна.	
1.3.8	Эрүүл мэндийн байгууллагуудын барилгын засвар үйлчилгээг үе шаттай хийж гүйцэтгэх.	1055.0	Барилгын засвар үйлчилгээ хийгдсэн байгууллагын тоо-	7	Аймгийн Нэгдсэн эмнэлгийн хүлээн авах сэхээн амьдруулах тасаг, Хангал, Бүрэгхангай сумдын эрүүл мэндийн байгууллагуудын барилгын их засвар.	Аймгийн Нэгдсэн эмнэлгийн яаралтай тусламж, сэхээний тасгийн их засварын ажил аймгийн Худалдан авах ажиллагааны газар тендер зарлагдаж Гурван уулын хишиг компани шалгарч гэрээ байгуулан засварын ажил 70%, Бүрэгхангай сумын ЭМТ-ийн барилгын их засвар Барс оргил компани шалгарч гэрээ байгуулан засварын ажил 60%, хийгдэж байна.Хангал сумын ЭМТ их засвар Соотон чоно ХХК шалгарч 2025 онд гадна пасад, хаалга, цонх хийгдэж 2026 онд дотор засал хийгдэж улсын комисс хүлээлгэж өгөхөөр санал хүргүүлсэн байна.	70
1.3.9	Эрүүл мэндийн байгууллагуудын	20.0	Батлагдсан зураг төсвийн тоо-	2	Гурванбулаг, Хишиг-Өндөр	Гурванбулаг СЭМТ-ийн барилгын засварын ажлын зураг төсөв хийгдсэн,	50

	барилгын зураг, төсөв боловсруулж батлуулах.				сумдын ЭМБ-уудын барилгын засварын ажлын зураг төсвийг боловсруулах.	Баяннуур сум, Хялганат тосгоны ЭМТ-ийн барилгын их засварын ажлын зураг төсөв хийгдэж байна. Хишиг-Өндөр СЭМТ аймгийн ИТХ-н 2026 оны XV/114 дүгээр тогтоолоор шинэ барилгатай болсон тул зураг төсөв хийлгэх шаардлагагүй болсон.	
1.3.10	Эрүүл мэндийн байгууллагуудыг түргэн тусламжийн автомашинаар үе шаттай хангах.	320.0	Парк шинэчлэлт хийгдсэн автомашины тоо-	Баян-Агт сумын ЭМТ 1	Бугат, Хангал, Орхон, Бүрэгхангай	Орон нутгийн төсвийн хөрөнгөөр оны эхний 6 сарын байдлаар 160.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй Орхон, Бүрэгхангай сумдын ЭМТ-үүдийг түргэн тусламжийн автомашинаар хангах тендер зарлагдаж, “Эм, Жи, ЭМ глобал моторс” ХХК шалгарч гэрээ хийгдэхээр төлөвлөгдөж байна. Бугат, Хангал сумдын ЭМТ-ийн түргэн тусламжийн автомашиныг шийдвэрлүүлэхээр Эрүүл мэндийн сайдад хүсэлт хүргүүлсэн	50
1.3.11	Эрүүл мэндийн байгууллагуудыг нэн шаардлагатай тоног төхөөрөмжөөр үе шаттай хангах шаардлагатай хөрөнгө санхүүжилтийг улс,орон нутгийн төсөвт тусган шийдвэрлүүлэх арга хэмжээг зохион байгуулах	ОНТ-115.0	Тоног төхөөрөмжийн хангалтын хувь	93.2	94.3	Оны эхний 5 сарын байдлаар Орон нутгийн төсвийн хөрөнгөөр Баяннуур, Гурванбулаг сумдын ЭМТ-дийг 29.1 сая шүдний бор, Нэгдсэн эмнэлэгт жень экспертийн аппарат 85.0 сая, гадаад дотоодын хандив тусламжаар Могод сумын ЭМТ-д хүчилтөрөгчийн аппарат, Сайхан сумын ЭМТ-д зүрхний эхо аппарат нийт 63.8 сая, Нэгдсэн эмнэлэгт 21.1 сая төгрөгийн сургалтын тоног төхөөрөмж, нярайн шарлагын аппаратаар зэрэг тоног төхөөрөмжөөр хангагдсан. Хялганат тосгоны ЭМТ-д мөн бор машины 19.9 сая төгрөгийн санхүүжилт шийдэгдэж гэрээ байгуулах шатанд хүлээгдэж байна	100
1.3.12	"Эрүүл Булган" хөтөлбөрийн 2026 оны төлөвлөгөөт үйл ажиллагааг хэрэгжүүлэх.	150,0	Тухайн оны төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь	88%	90%	"Эрүүл Булган" хөтөлбөрийг боловсруулан Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн VI/32 дугаар тогтоолоор батлуулан хэрэгжилтийг ханган ажиллаж байна Хавдрын эрт илрүүлэгт нийт 421 иргэн хамрагдаж хагас жилийн байдлаар аймгийн хэмжээнд эрт илрүүлэг үзлэгийн хамрагдалт 50.8%-д	70

						хүрч, өмнөх оноос 0.3%-иар өссөн байна. "Эрүүл шүд" хөтөлбөрийн хүрээнд 18 хүртэлх насны хүүхдийн шүд, амны хөндийн эрүүл мэндийг сайжруулах, үзлэг, эмчилгээ, зөвлөгөө өгөхөөр Баяннуур, Бүрэгхангай сумын эрүүл мэндийн төв "Ц.Бадрал" сан, АШУИС-ийн Нүүр ам судлалын сургуультай хамтран үзлэг зохион байгуулан 823 хүүхдэд амны хөндийн урьдчилан сэргйлэх үзлэг, 268 хүүхдийн 881 цооролтой шүдийг эмчилсэн байна. Аймгийн Засаг дарга болон НЭМҮТ-ийн хооронд байгуулсан хамтын ажиллагааны гэрээний хүрээнд халдварт бус өвчин, тэр дундаа хорт хавдрын эрсдэлт хүчин зүйлийг судлах ажлыг НЭМҮТ шалгарсан тендерийн дагуу хэрэгжүүлж, 2019–2025 оны хорт хавдрын тохиолдолд дүн шинжилгээ хийх, хүн амын дундах эрсдэлт хүчин зүйлийн түүврийн судалгаа явуулах, ус хөрсний дээжид лабораторийн шинжилгээ хийх, эмч мэргэжилтнүүдийг арга зүйн дэмжлэгээр хангах болон урьдчилан сэргийлэх сурталчилгааны ажлыг зохион байгуулахын зэрэгцээ энэхүү судалгааны үр дүнг "Булганы сэргэлт", "Эрүүл Булган" хөтөлбөрийн хүрээнд бодлого, төлөвлөлтийг нотолгоонд суурилсан байдлаар сайжруулахад ашиглах зорилготой бөгөөд уг ажлын нээлтийн хүрээнд сумдын удирдлагад мэдээлэл өгч, Судалгааны арга зүй сургалтыг 50 эмч мэргэжилтэнд зохион байгуулсан. Хүн амд эрүүл мэндийн боловсрол олгох чиглэлээр 16 удаагийн танхимийн сургалтанд 736 иргэдийг хамруулж, сурталчилгаанд давхардсан тоогоор 7483 иргэнийг хамруулсан.	
--	--	--	--	--	--	--	--

						Эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх, эрүүл мэндийн мэдээлэл, сургалт, сурталчилгааны видео шторк зэрэг 53 удаагийн мэдээ, мэдээллийг ил тод, нээлттэй байдлаар түгээж, пэйж хуудсаар дамжуулан нийт 57,312 иргэн мэдээлэл авч, зөвлөгөө, зөвлөмжөөр хангасан. Олон нийтийн эрүүл мэндийн ажилтан, нийгмийн эрүүл мэндийн ажилтнуудыг чадавхжуулах нь” сургалтыг Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төвтэй хамтран цахим хэлбэрээр зохион байгуулж, сургалтад 16 сум болон өрхийн эрүүл мэндийн төвийн нийт 56 эмч, эмнэлгийн мэргэжилтэн хамрагдсан	
1.3.13	Эрүүл мэндийн Байгууллагын эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдийг дотоодын болон өндөр хөгжилтэй оронд урт болон богино хугацаанд ажиллангаа суралцан мэдлэг, ур чадвараа тасралтгүй хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх хөрөнгийг шийдвэрлүүлэх	ОНТ-130	Хамрагдсан эмч, мэргэжилтний тоо	36	105	ОХУ-1, БНСУ-ын Сон-Э эмнэлэгт 1, нийт гадаад сургалтад 2, дотоодын богино хугацааны 55 чиглэлийн сургалтад давхардсан тоогоор 850 эмч, эмнэлгийн мэргэжилтэн хамрагдсан.	100
1.3.14	Баг, сумын эрүүл мэндийн төвийн эмч нарыг дулаан хувцас, амьдрах орон байр зэрэг нийгмийн баталгааг сайжруулан, тогтвор суурьшилтай ажиллахад дэмжлэг үзүүлэх	ОНТ-70	Дэмжлэг үзүүлсэн эрүүл мэндийн салбарын албан хаагч	17	20	Аймгийн Нэгдсэн эмнэлэг, Сайхан сумын ЭМТ-үүд ургалтад хамрагдаж буй 9 эмч мэргэжилтний нийгмийн баталгааг дэмжих үүднээс сургалтад хамрагдах хугацаанд цалин хөлсийг бүрэн олгож байна. Хишиг-өндөр сумын ЭМТ 2 зөөврийн орон сууцанд, өвлийн түлш /2 портер машин нүүрс/, Могод ЭМТ- хүнсний дэмжлэг /Зхонь/, 1 мэргэжилтнийг амьдрах байраар, Дашинчилэн суманд 1 зөөврийн сууцанд 1 мэргэжилтнээ хамруулсан, хүнсний дэмжлэг үзүүлсэн	100

						/2хонь/, Рашаант сумын ЭМТ бүх ажилчдаа ээлжийн хувцсаар хангасан, 5 албан хаагчийг амралтанд амрах эрхээр урамшуулан амраасан. Хутаг-Өндөр сумын ЭМТ-н 2 мэргэжилтэн төрийн албан хаагчийн байранд, Бүрэгхангай сумын ЭМТ 1 албан хаагчийг малжуулах төсөлд хамрагдан 30 бог өгсөн, 1 сувилагч, 1 их эмч, 1 лаборант төрийн албан хаагчийн байранд, 1 их эмч сумаас олгосон байранд амьдарч байна.	
			Зарцуулсан хөрөнгө	40	50	Нийт 31 сая төгрөг зарцуулсан	100
1.4	Салбарын сайдтай байгуулсан гэрээнд тусгагдсан зорилт, арга хэмжээ.						
1.4.1	Халдварт өвчинтэй тэмцэх сэргийлэх арга хэмжээний төлөвлөгөөг хэрэгжүүлэх.		10,000 хүн амд ногдох халдварт өвчний түвшин	96	90	Халдварт өвчинтэй тэмцэх сэргийлэх арга хэмжээний 2026 оны ажлын төлөвлөгөөг 8 зорилт 58 арга хэмжээний хүрээнд төлөвлөн хэрэгжилтийг ханган ажиллаж байна. 2026 оны эхний 05 сарын байдлаар аймгийн хэмжээнд халдварт өвчний 121 буюу 10,000 хүн амд 20,5 тохиолдол бүртгэгдсэн. Энэ нь өнгөрсөн оны мөн үеэс 37 тохиолдлоор нэмэгдсэн үзүүлэлтэй байна. Улаанбурхан өвчний 6 тохиолдолд тандалт судалгаа хийж, хавьтлын 87 хүнийг голомтын дархлаажуулалтад хамруулсан. БЗДХ илрүүлэх шинжилгээнд 2758 хүнийг хамруулж, тэмбүүгийн 7, заг хүйтний 17 тохиолдлыг шинээр илрүүлэн эмчлэн эрүүлжүүлсэн. Халдварт өвчний чиглэлээр эмч эмнэлгийн мэргэжилтнүүдийг чадваржуулах цахим сургалтыг 3 удаа зохион байгуулж, давхардсан тоогоор 86 эмнэлгийн мэргэжилтнийг хамруулсан. Иргэд олон нийтэд чиглэсэн халдварт өвчнөөс сэргийлэх сургалтыг 1 удаа зохион байгуулж, 32 иргэнийг,	100

						сурталчилгааг 32 удаа хийж, 374 иргэнийг тус тус хамруулсан. Эрүүл мэндийн байгууллагуудын цахим хуудсаар халдварт өвчнөөс сэргийлэх талаарх 2 төрлийн зурагт хуудас, анхааруулга, мэдээлэл зөвлөмжийг 38 удаа түгээсэн. Заавал хийх дархлаажуулалтын хамралт 98.8%-тай байна.	
1.4.2	Сэтгэцийн эрүүл мэнд арга хэмжээний төлөвлөгөөг хэрэгжүүлэх.	-	Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь	94	95	Сэтгэцийн анхан шатны тусламж үйлчилгээг өргөжүүлэх, чанар хүртээмжийг сайжруулах арга барил эзэмшүүлэх сургалтыг тасралтгүй явуулан mhGAP хөтөлбрийн хэрэгжилтийг эрчимжүүлэн цаг тухай бүрт мэргэжил аргагүйн зөвлөгөөг өгч ажиллаж байна. АНЭ-ийн сэтгэцийн тасаг 2026 оны 6 сарын байдлаар жилийн эцсээр 21 иргэн архины эмчилгээнд хамрагдаж урьдчилан сэргийлэх үзлэг шинжилгээнд оруулсан эмчлэн эрүүлжүүлэх нийгэмшүүлэх болон харшил үүсгэх өвөрмөц эмчилгээ болон ганцаарчилсан, бүлгийн сэтгэл засал эмчилгээ хийж ажилласан. Сэтгэцийн эрүүл мэндийн анхан шатны тусламж, үйлчилгээг нэмэгдүүлэх зорилгоор Улсын гуравдугаар төв эмнэлэг болон СЭМҮТ-тэй хамтран цахим сургалт зохион байгуулж, 16 сум, ӨЭМТ-ийн нийт 57 эмч, эмнэлгийн мэргэжилтэн, багийн эмчийг хамрууллаа. Мөн НЭМҮТ, СЭМҮТ-тэй хамтран өсвөр үеийнхний эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх, зөв дадал төлөвшүүлэх чиглэлээр үе тэнгийн сургагч багш нарт сургалт зохион байгуулж, 22 сургуулийн 421 сурагчийг хамруулсан. Түүнчлэн Ерөнхий боловсролын 2 дугаар сургуулийн 7 ангийн 5 бүлгийн 236	100

						сурагчид цахим донтолт, сэтгэл гутрал, үе тэнгийн дээрэлхэлтийн талаар сургалт мэдээлэл хүргэсэн. Мөн ХХҮГ, ОБГ, ШШГ, ШШГГ, БОГ зэрэг байгууллагын 184 албан хаагчийг хорт зуршлаас урьдчилан сэргийлэх сургалт, мэдээлэлд хамруулж, нийт 898 иргэн, сурагч, албан хаагч, эрүүл мэндийн ажилтныг сэтгэцийн эрүүл мэндийг дэмжих үйл ажиллагаанд хамруулсан.	
1.4.3	Осол гэмтлээс урьдчилан сэргийлэх хүрээнд Хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтийг хангаж ажиллах.	-	Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь	0	90	Иргэдэд осол гэмтлээс урьдчилан сэргийлэх мэдлэг, хандлага олгох, ахуйн болон зам тээврийн ослын эрсдлийг бууруулах, анхны тусламжийн мэдлэгийг нэмэгдүүлэхэд чиглэсэн дараахь ажлыг төлөвлөж хийсэн. Үүнд:Осол гэмтлийн үед “Гэмтлийн үеийн эрэмбэлэн ангилалт”, “Амилуулах суурь тусламж үзүүлэх” сэдвээр Сайхан, Рашаант, Баян-Агт, Бүрэгхангай, Орхон, Сэлэнгэ, Бугат суманд байгуулж, 2734 иргэнийг хамруулсан. • “Хүүхдийг аюулгүй тээвэрлэх” сэдвээр видео контент бэлтгэн цахим байршуулсан. Хүүхдийг аюулгүй тээвэрлэх” видео контентийн нийт үзэлт нь 8041, 3 секундйн үзэлт нь 3702 байна. Үзэлтийн дундаж хувь нь 6 байна. Хуваалцсан 84, хариу үйлдэл буюу таалагдсан 19%. Контентын нийт үзэлт нь 35-44 насанд 30%, 25-34 насныхан 29.4 хувь, 45-54 насныхан18 хувь, 55-64 насныхан 17 хувь, 18-24 насныхан 6.9 хувь, 65-аас дээш насныхан нь 4,5 хувийг эзэлж байна.	100

						• Аймгийн Нэгдсэн эмнэлгийн гэмтлийн их эмч, сувилагч нар хэвтэн эмчлүүлэгч нарт осол гэмтлээс урьдчилан сэргийлэх, анхны тусламж сэдвээр давхардсан тоогоор 260 иргэнд сургалт зохион байгуулсан. “Могойд хатгуулсан үед авах арга хэмжээ”, “Усанд живсэн хүнд үзүүлэх тусламж”, “Түлэгдэлтийн үед үзүүлэх тусламж”, “Осголт, хөлдөлтийн үед авах арга хэмжээ” сэдвээр боршур хийж, эмнэлгээр үйлчлүүлэгчдэд зөвлөмж өгсөн. • Аймгийн Нэгдсэн эмнэлгийн гэмтлийн эмч Д.Алтангэрэл 2026 оны 3 дугаар сарын 24-ний 2-р 12 жилийн сургуулийн 7 дугаар ангийн 5 бүлгийн 161 сурагчдад “Гамшиг, ослын үед үзүүлэх анхны шатны тусламж” сэдэвт сургалтыг зохион байгуулж, ослын үед амь насыг аврах суурь арга хэмжээ, анхны тусламжийн үндсэн зарчмуудыг танилцуулсан. • Аймгийн ОБГ-ын эрсдлийн үнэлгээний мэргэжилтэнтэй хамтран “Гамшгийн эрсдлийн үнэлгээний заавар”-ын дагуу аймгийн Нэгдсэн эмнэлэг, Дашинчилэн сумын эмнэлэгт тохиолдож болзошгүй гамшгийн эрсдлийн ерөнхий үнэлгээг хийж, эрсдлийг бууруулах арга хэмжээний зөвлөмж хүргүүлсэн. • ЭМГ, 7 сумын Эрүүл мэндийн төвийн ажлын байранд галын аюулгүй байдлын дүгнэлт хийлгэсэн.	
--	--	--	--	--	--	---	--

						“Хуульчийн Про Боно–2026” өдөрлөгөөр Эрүүл мэндийн газар, өрхийн Эрүүл мэндийн төвүүд, “Монос” эмийн сангийн хамт олон хамтран ажиллаж, иргэдэд хорт зуршлаас урьдчилан сэргийлэх, осол гэмтлээс сэргийлэх, эмийн зохистой хэрэглээний талаар зөвлөгөө мэдээлэл өгч, анхан шатны тусламж үйлчилгээг үзүүлж ажилласан. - ЭМБ-уудын жолооч нарт “Аюулгүй тээвэрлэлт” сэдвээр сургалт зохион байгуулсан.	
1.4.4	Лавлагаа шатлалын болон анхан шатны эрүүл мэндийн байгууллагуудад алсын зайн анагаах ухаан (телемедицин)-ний ашиглалтыг нэмэгдүүлэх		Телемедициний ашиглалт нэмэгдсэн байгууллагын тоо	19	19	Аймгийн нэгдсэн эмнэлэг ,сум, өрхийн эрүүл мэндийн төвүүд хооронд google meet-ээр 3 удаа 85 эмч, эмнэлгийн алба хаагчид холбогдож, мэдээ мэдээлэл солилцсон байна. Лавлагаа шатлалын эмнэлэгтэй телемедицинээр холбогдоогүй байна.	100
Хоёр. Хуулиар тусгайлан олгосон чиг үүргийг хэрэгжүүлэх зорилт, арга хэмжээ							
2.1.	Эрүүл ахуй, халдвар хамгааллын хяналтын чиглэлээр их, дунд эрсдэлтэй үнэлэгдсэн 30 объектод төлөвлөгөөт шалгалт хийх.	Улсын төсөв	Шалгалт хийсэн объектын гүйцэтгэлийн хувь	93%	95%	Эхний хагас жилд 26 объектод төлөвлөгөөт хяналт шалгалт хийж, хамрагдалт 86.7%-тай. Хяналтад хамрагдсан 26 объектыг 12 төрлийн 29 хяналтын хуудсаар шалгахад 3 (10.3%) их, 14 (48.3%) дунд, 12 (41.3%) бага эрсдэлтэй үнэлэгдсэн. Нийт 181 зөрчил илрүүлж, 5 (2.8%)-г шалгалтын явцад арилгуулан, 170 заалттай 15 улсын байцаагчийн албан шаардлага бичиж, хөрсний-16, усны-42, агаарын-3, арчдасны-30, хүнсний бүтээгдэхүүний-1, савласан усны-2 нийт 94 дээжинд улсын байцаагчийн 7 дүгнэлт үйлдэв. Улсын байцаагчийн 8 заалттай 2 зөвлөмж 2 ААНБ-д хүргүүлсэн байна. Албан шаардлагын биелэлт тооцох	100

						хугацаа болоогүй, хяналт шалгалт үргэлжилж байна.	
			Албан шаардлагын хэрэгжилтийн хувь	70.3%	72.5%	63,3%	90
			Хууль сахин мөрдөлтийн түвшин (хувиар)	66.9%	68.0%	0	100
Гурав.Хуулиар олгосон нийтлэг чиг үүргийг хэрэгжүүлэх зорилт, арга хэмжээ							
3.1	Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн дагуу нийтийн мэдээлэл хариуцагч байгууллагуудын мэдээллийг shilen.gov.mn цахим хуудаст тухай бүр байршуулж ажиллах, хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангаж ажиллах	-	Тайлан илгээж баталгаажуулсан тоо	4	4	Нээлттэй мэдээллийн ил тод байдлын www.shilen.gov.mn системд байгууллагын үйл ажиллагаатай холбоотой мэдээ мэдээллийг тухай бүр байршуулан, баталгаажуулж байна.	100
		-	Хэрэгжилтийн хувь	-	100%	Улирал бүр нээлттэй мэдээллийн ил тод байдлын www.shilen.gov.mn системд байгууллагын үйл ажиллагаатай холбоотой мэдээ мэдээллийг ил тод байршуулж, иргэдэд нээлттэй хүргэж байна. 2026 оны 1-р улиралд 99.26% үнэлэгдсэн.	100
3.2	Нээлттэй хаалганы өдрийг улирал бүрт зохион байгуулж, тайланг Төрийн захиргааны удирдлагын хэлтэст ирүүлэх	-	Арга хэмжээний тоо	-	2 удаа зохион байгуулсан байна	Хуульчийн Про Боно–2026” өдөрлөгөөр Эрүүл мэндийн газар, өрхийн Эрүүл мэндийн төвүүд, “Монос” эмийн сангийн хамт олон хамтран ажиллаж, 112 иргэнд хорт зуршлаас урьдчилан сэргийлэх, осол гэмтлээс сэргийлэх, эмийн зохистой хэрэглээний талаар зөвлөгөө мэдээлэл өгч, 32 иргэнд анхан шатны тусламж үйлчилгээг үзүүлж ажилласан.	100
		-	Үйлчилгээ авсан иргэдийн тоо	-	100-с доошгүй хүн хамруулсан байна.	Өдөрлөгийн үеэр 112 иргэнд хорт зуршлаас урьдчилан сэргийлэх, осол гэмтлээс сэргийлэх, эмийн зохистой хэрэглээний талаар зөвлөгөө мэдээлэл өгч, 32 иргэнд анхан шатны тусламж үйлчилгээг үзүүлж ажилласан.	100
3.3	Иргэдээс ирсэн өргөдөл, гомдол, саналыг хүлээн авч хуулийн хугацаанд	-	Шийдвэрлэлтийн хувь	-	100 хувь	Байгууллагад ирсэн өргөдөл гомдол, санал хүсэлт 32-ийг хүлээн авч, 31 өргөдлийг шийдвэрлэж, 1 өргөдөл	100

	шийдвэрлэн, хэрэгжилтийг улирал тутам тайлагнах, албан ёсны цахим хуудаст өргөдөл гомдлын цэс үүсгэх					шийдвэрлэгдэх хугацаа болоогүй, өргөдлийн шийдвэрлэлт 95,5% байна.	
		-	Тайлан илгээсэн тоо	4	4	Эхний хагас жилийн байдлаар 2 удаа тайланг хүргүүлсэн.	100
3.4	Төрийн байгууллагууд албан хэрэг хөтлөлтөд тоон гарын үсгийг 100 хувь ашиглаж хэвших	-	Ашиглалтын хувь	-	100 хувь	Эрүүл мэндийн байгууллага бүр албан хэрэг хөтлөлт, мэдээлэл солилцооны http://eoffice.bulgan.gov.mn/ системг даргын тоон гарын үсгийн баталгаажилтаар 100% үйл ажиллагаандаа ашиглаж байна.	100
3.5	Байгууллагын албан хаагчдын сургалт, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийг хэрэгжүүлэн ажиллах, Төлөвлөгөөг Төрийн захиргааны удирдлагын хэлтэст 2026 оны 1 дүгээр улиралд багтаан ирүүлэх	-	Хэрэгжилтийн хувь	-	90-с доошгүй хувь	Төрийн албан хаагчийн сургалт нийгмийн баталгааны хөтөлбөрийн 2026 оны төлөвлөгөөний хэрэгжилтийг 9 заалтаар гарган 2026.06.11-ны өдрийн 02/343 тоот албан бичгээр хүргүүлсэн.	100
		-	Хүргүүлсэн төлөвлөгөөний хувь	-	1	Төлөвлөгөөг хүргүүлсэн.	100
3.6	Төрийн байгууллагуудын Ёс зүйн дэд хороог чадавхижуулах сургалтыг зохион байгуулж, төрийн албан хаагчдыг соён гэгээрүүлэх сургалт мэдээллийг улирал бүр зохион байгуулах	-	Зохион байгуулсан сургалтын тоо	-	4	ЭМГ-ын ёс зүйн дэд хорооны гишүүд ёс зүйн цахим 1, танхимын 1 сургалтад нийт 2 удаа, 19 байгууллагын ёс зүйн багийн гишүүдийг чадавхижуулах сургалтад хамруулсан.	100
		-	Хамрагдсан албан хаагчдын тоо	-	150	Ёс зүйн дэд хороо, эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн салбар хорооны 19 мэргэжилтнийг, ЭМБ-уудын 80 эмч, эмнэлгийн мэргэжилтнийг хамруулсан.	100
3.7	Төрийн албаны тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах, зөрчил бүхий томилгоо хийхгүй байх.	-	Хэрэгжилтийн хувь	-	100	Төрийн албаны тухай хууль болох холбогдох бусад хууль тогтоомж зөрчиж хийгдсэн томилгоо байхгүй.	100
3.8	Төрийн албан хаагчдыг салбарын хэмжээнд гадаад, дотоодын туршлага судлуулах, мэдлэг чадвараа дээшлүүлэх нөхцөл боломжоор хангах.	-	Гадаад сургалтын тоо	-	1	БНСУ-ын Сон-Э эмнэлэгт 1 их эмчийг, ОХУ-д 1 их эмчийг богино хугацааны сургалтад хамруулахаар бэлтгэл ажил хангагдаад байна.	80
		-	Дотоод сургалтын тоо	-	4	ЭМЯ, ЭМХТ, УГТЭ, УНТЭ, УХТЭ, АШУУИС болон холбогдох бусад нийгэмлэг холбоод мэргэжлийн	100

						байгууллагуудтай хамтран зохион байгуулсан дотоодын богино хугацааны 55 чиглэлийн сургалтад давхардсан тоогоор 850 эмч, эмнэлгийн мэргэжилтэн хамрагдсан.	
3.9	Төрийн албан хаагчдыг мэргэшүүлэх сургалтад үе шаттай хамруулах ажлыг зохион байгуулах	-	Мэргэшүүлэх сургалтад хамрагдсан ТАХ-ийн тоо	-	4	Төгсөлтийн дарах мэргэшил олгох, дээшлүүлэх хаврын сургалтад 9 эмч эмнэлгийн мэргэжилтнийг төрийн сангийн сургалтад хамруулсан.	100
3.10	“Тэрбум мод” үндэсний хөдөлгөөн, Бүх нийтээр мод бут тарих ажилд зохион байгуулалттайгаар оролцох (1 хүн 5 мод тарих)	-	Тарьсан модны тоо	100 ш мод тарьсан	Албан хаагч бүр 5-с доошгүй мод тарьсан байна	“Тэрбум мод” үндэсний хөтөлбөрийн хүрээнд байгууллагын нийт албан хаагчид хуваарьт газартаа 90 ширхэг мод тарьсан	100
3.11	"Цэвэр орчин-цэмцгэр Булган" аянд идэвхитэй оролцож, бүх нийтийн цэвэрлэгээнд оролцох (зам дагуу хог цэвэрлэгээний ажил, орчны 50 метрийн хог хаягдал, хог ургамал, цас мөсийг арилгах)	-	Зохион байгуулсан нийтийн цэвэрлэгээний ажилд идэвхтэй оролцох	Аянд нэгдэж тайлан мэдээг хүргүүлэн ажилласан	2-с доошгүй удаа хийсэн байна	Цэвэр орчин-Цэмцгэр Булган" аяны хүрээнд Төлүүгийн даваанаас доош 2км, замын хажуугийн хог, хаягдлыг зайлуулж, тайланг холбогдох байгууллагад хүргүүлсэн	100
3.12	Аймгийн Засаг даргын 2025 оны 12 сарын 09-ний өдрийн А/766 дугаар “Дотоодын худалдан авалтаар дэмжих” захирамжийн хэрэгжилтийг хангах	-	Захирамжийн хэрэгжилтийн хувь	-	100	Захирамжийн хэрэгжилтийг бүрэн ханган ажилласан.	100
3.13	(Төсвийн байгууллагын хэрэгцээтэй бараа, ажил үйлчилгээг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу орон нутгаас худалдан авах)	-	Нийт худалдан авалтад дотоодын худалдан авалтын эзлэх хувь	-	80-с доошгүй хувь	Эхний хагас жилд батлагдсан бараа материалын зардал 13,644.0 мянган төгрөгийн төсвийг 100 хувь орон нутагт ажил үйлчилгээ явуулж буй аж ахуйн нэгж ,байгууллагаас худалдан авалт хийсэн. Үүнд: тээвэр шатахуун-10,647.6мян₮-ийг Шунхлай ХХК, интернэт-880,0 мян₮-ийг Булган интернэт ХХК, бичиг хэргийн материал -	100

						1,369.2 мян₮ Минжваанжил ХХК-аас оны эхэнд гэрээ хийн хамтран ажиллаж байна.	
3.14	Албан хаагчдыг нас, хүйс, эрүүл мэндийн онцлогт тохирсон урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэг үзлэгт хамруулах.	-	Хамрагдалтын хувь	-	100	Байгууллагын албан хаагчдыг урьдчилан сэргийлэх үзлэгт 2 дугаар хагас жилд хамруулахаар хуваарь гарган төлөвлөн ажиллаж байна.	50
3.15	“Үндэсний бичиг соёлын жил”, “Эх хэлний өдөр”, “Үндэсний хувцасны өдөр” зэрэг арга хэмжээг түгээн дэлгэрүүлж, “Хос бичигтэн” уриалгыг гаргаж, үндэсний бичиг соёлыг сурталчилан таниулах ажлыг зохион байгуулах.		Зохион байгуулсан арга хэмжээний тоо	-	2	Аймгийн Засаг даргын 2025 оны А/145 тоот захирамжийг хэрэгжүүлэн, сар бүрийн эхийн 7 хоногт албан хаагчид үндэсний хувцас, монгол дээл өмсөж хэвшсэн. Албан хаагчдын Гүйцэтгэлийн төлөвлөгөөнд монгол бичгийн уншиж, бичих чадвараа сайжруулах талаар заалт тусган, хэрэгжилтийг ханган ажиллаж байна. “Үндэсний бичиг соёлын жил”, “Эх хэлний өдөр”, “Үндэсний хувцасны өдөр” зэрэг арга хэмжээг түгээн дэлгэрүүлж, Эрүүл мэндийн газрын даргын 2021 оны А/09 дүгээр тушаалаар ажлын хэсгийг 5 хүний бүрэлдэхүүнтэй байгуулж “Хос бичигтэн” уриалгыг өрнүүлж, үндэсний бичиг соёлыг сурталчлан таниулах үйл ажиллагааг тогтмол зохин байгуулан, иргэд олон нийтийн оролцоог нэмэгдүүлж ажилласан. Нийт албан хаагчдын компьютерт монгол бичгийн үсгийн фонт суулган, цахим бичвэрийн сургалтын гарын авлагыг танилцуулсан.	100
			Хамрагдалтын хувь	-	100	Нийт төрийн албан хаагчдыг хамруулсан.	100
3.16	Иргэдийн дунд сайн дурын авлагагүй донорын эгнээг өргөжүүлж аюулгүй цус, цусан бүтээгдэхүүн и й бэлдмэлийн хангамжийг	-	Донорын тоо Цус цусан бүтээгдэхүүний хангамж, нөөцийн хувь	Донорын тоо-1500 Цус цусан бүтээгдэхүүн ий хангамж,	Донорын тоо-1600 Цус цусан бүтээгдэхүүний хангамж, нөөцийн хувь-100%	Аймгийн Нэгдсэн эмнэлгийн цусны салбар төвөөс Сэлэнгэ, Хялганат, Сайхан, Баян-Агт, Орхон, Баяннуур сумын эрүүл мэндийн төвийн 121 мэргэжилтэнд “Цус цусан бүтээгдэхүүний аюулгүй хэрэглээ”	100

	нэмэгдүүлэх.			нөөцийн хувь-100%		сургалт, 151 иргэдэд “Цусны донорын тухай” сэдэвт сургалт хийсэн. Бугат, Баяннуур, Орхон сумын 82 иргэнд цусны шинжилгээ хийж, 37 иргэнийг шинээр донорын эгнээнд элсүүлсэн.	
3.17	Шилэн дансны хуулийн хэрэгжилтийг ханган, салбарын хэмжээнд хяналт тавьж ажиллах.		Хэрэгжилтийн тоон үзүүлэлт, хувь	97	98	Эхний хагас жилд шилэн дансны хэрэгжилтийг Эрүүл мэндийн 20 байгууллагын 15 үзүүлэлтээр 1354 удаагийн мэдээллээс 19 удаагийн мэдээллийг хугацаа хоцроож 98.7 хувийн биелэлтэй гарлаа. Шилэн дансны мэдээллийг хугацаа хоцорсон эрүүл мэндийн төвүүд /Баян-агт,Бүрэгхангай ЭМТ тус бүр-1, Бугат,Орхон, Могод сумын ЭМТ тус бүр 2, Хутаг-өндөр сумын ЭМТ-3, Сайхан, Хялганат сумын ЭМТ тус бүр-4/	100
3.18	Байгууллагын ил тод, нээлттэй байдлыг ханган, олон нийтийг хууль журамд заагдсан мэдээллээр хангах, нээлттэй мэдээллийн ил тод байдлын шил ажиллагааны системд мэдээлэл байршуулан хугацаанд нь илгээх.		Цахимд байршуулж баталгаажсан мэдээллийн тоо-	96.8	97.0	Нээлттэй мэдээллийн ил тод байдлын www.shilen.gov.mn системд байгууллагын үйл ажиллагаатай холбоотой мэдээ мэдээллийг тухай бүр байршуулан, баталгаажуулж байна. . 2026 оны 1-р улиралд 99.26% үнэлэгдсэн.	100
3.19	Салбарын хэмжээнд Санхүүгийн сахилга Хариуцлагыг сайжруулах.	-	Өөрчлөлтгүй дүгнэлт авсан байгууллагын тоо	18	18	Харьяа эрүүл мэндийн 20 байгууллагын 35.1 тэрбум төгрөгийн 2025 оны төсвийн гүйцэтгэл,жилийн эцсийн санхүүгийн тайланг нэгтгэн, аудитын дүгнэлтийн хамт Эрүүл мэндийн яамны санхүүгийн хэлтэст анхан шатны 2 боть баримт хамт хуулийн хугацаанд биеэр очиж тушаасан. Нийтдээ харьяа 20 байгууллагаас 18 нь “Зөрчилгүй” дүгнэлт,Хутаг-өндөр сумын ЭМТ,Орхон сумын ЭМТүүд “Хязгаарлалттай дүгнэлт” авсан.	100
3.20	Эрүүл мэндийн байгууллагуудын төсвийн өөрчлөлтийг “Төсвийн	-	Төсвийн хуваарьт өөрчлөлт оруулсан байгууллагын тоо	18	18	Тайлант хугацаанд Эрүүл мэндийн байгууллагуудын эрх нээх хүсэлт-8, төсвийн хуваарьт өөрчлөлт оруулах	100

	тухай” хуулийн 42, 45, 46 дугаар зүйл, заалтын дагуу захиалагчид бичгээр хүсэлт гаргаж шийдвэрлүүлнэ.					санал-11, нийт 4 удаагийн давхардсан тоогоор 19 байгууллагын саналыг нэгтгэн ЭМЯ-д хүргүүлж шийдвэрлүүлсэн байна	
3.21	Төрийн албан хаагчдын сургалт, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийг хэрэгжүүлэх.	Орон нутаг 40.0 сая төгрөг	-Сургалтад хамрагдсан ТАХ-ын тоо -Дэмжлэг үзүүлсэн ТАХ-ын тоо, мөнгөн дүн	Сургалтад хамрагдсан ТАХ-ын тоо-1450 /давхардсан тоогоор/ -Дэмжлэг үзүүлсэн ТАХ-ын тоо 20, мөнгөн дүн-	Сургалтад хамрагдсан ТАХ-ын тоо -1500 /давхардсан тоогоор/ -Дэмжлэг үзүүлэх ТАХ-ын тоо 5, мөнгөн дүн- сая төг	Дотоодын богино хугацааны 55 чиглэлийн сургалтад давхардсан тоогоор 850 эмч, эмнэлгийн мэргэжилтэн хамрагдсан. Аймгийн Нэгдсэн эмнэлэг, Сайхан сумын ЭМТ-үүд ургалтад хамрагдаж буй 9 эмч мэргэжилтний нийгмийн баталгааг дэмжих үүднээс сургалтад хамрагдах хугацаанд цалин хөлсийг бүрэн олгож байна. Хишиг-өндөр сумын ЭМТ 2 зөөврийн орон сууцанд, өвлийн түлш /2 портер машин нүүрс/, Могод ЭМТ- хүнсний дэмжлэг /3хонь/, 1 мэргэжилтнийг амьдрах байраар, Дашинчилэн суманд 1 зөөврийн сууцанд 1 мэргэжилтнээ хамруулсан,хүнсний дэмжлэг үзүүлсэн /2хонь/, Рашаант сумын ЭМТ бүх ажилчдаа ээлжийн хувцсаар хангасан, 5 албан хаагчийг амралтанд амрах эрхээр урамшуулан амраасан. Хутаг-Өндөр сумын ЭМТ-н 2 мэргэжилтэн төрийн албан хаагчийн байранд, Бүрэгхангай сумын ЭМТ 1 албан хаагчийг малжуулах төсөлд хамрагдан 30 бог өгсөн, 1 сувилагч, 1 их эмч, 1 лаборант төрийн албан хаагчийн байранд, 1 их эмч сумаас олгосон байранд амьдарч байна.	100
Дөрөв.Төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах зорилт, арга хэмжээ							
4.1.1	Эрүүл мэндийн салбарын эмч, эмнэлгийн албан хаагчдыг хууль, эрх зүйн	-	Сургалтанд хамрагдсан албан хаагчдын эзлэх хувь	Хууль, эрх зүйн мэдлэг олгох сургалтанд	Хууль, эрх зүйн мэдлэг олгох сургалтанд эрүүл мэндийн салбарын	Төрийн болон албаны нууцын тухай хууль, Төрийн албаны тухай хууль, Авлигын эсрэг хууль, Эрүүл мэндийн тухай хууль, Нийгмийн эрүүл мэндийн	100

	мэдлэг олгох сургалтад хамруулах.			эрүүл мэндийн салбарын албан хаагчдын 60 хувийг хамруулсан.	албан хаагчдын 70 хувь	тусламж үйлчилгээний тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомжийн танхим болон цахимын 8 удаагийн сургалтад давхардсан тоогоор 320 албан хаагчийг хамруулсан.	
4.1.2	Эрүүл мэндийн салбарын эмч, эмнэлгийн мэргэжилтэн, ажилчдын ёс зүй, харилцаа хандлагыг сайжруулах сургалтад хамруулах.	-	Сургалтанд хамрагдсан албан хаагчдын эзлэх хувь	Ёс зүй, харилцаа, хандлагын сургалтанд нийгмийн салбарын албан хаагчдын 50 хувийг хамруулсан.	Ёс зүй, харилцаа, хандлагын сургалтанд нийгмийн салбарын албан хаагчдын 60 хувь-	ЭМХТ, АШУҮИС-ын мэргэжилтнүүдтэй хамтран зохион байгуулсан ёс зүй харилцаа хандлагыг сайжруулах танхимын сургалтад 99 эмч эмнэлгийн мэргэжилтнүүдийг хамруулсан.	100
	НИЙТ ХЭРЭГЖИЛТИЙН ХУВЬ						93.0

Мэдээлэл хариуцагч: ХШҮМХ-ийн дарга Б.Урангаваа

Утас: 99354952

Имэйл хаяг: b.urangavaa@bu.moh.gov.mn